

# ЭНЭ МЭДЭЭГ ОДООНООС АШИГЛАЖ БОЛНО.

ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА  
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

## Хэвлэлийн мэдээ

№. 02-14

2014 оны 3-р сарын 11

### **Монгол улсад олгох иений хөнгөлөлттэй зээл болон бусад хамтын ажиллагаатай холбоотой Ноот бичигт гарын үсэг зурах ёслол**

1. 3 дугаар сарын 11-ний өдөр Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайд Такэнори Шимизү болон Монгол улсын Гадаад харилцааны сайд Лувсанвандангийн Болд нар Гадаад харилцааны яамнаа иений хөнгөлөлттэй зээлийн 1 төсөл, буцалтгүй тусламжийн 2 төсөл /нийт дүн 8 тэрбум 356 сая 700 мянган иен/-ийн Ноот бичигт тус тус гарын үсэг зурав.

2. Төслүүдийн товч танилцуулга

/1/ Иений хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Инженер, технологийн дээд боловсрол” төсөл /Нийт дүн 7 тэрбум, 535 сая иен/

Уг төсөл нь өнгөрсөн оны 9 дүгээр сард Монгол улсын Ерөнхий сайд Н. Алтанхуягийн Япон улсад хийсэн айлчлалын үеэр батлагдсан “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-ийн дагуу Монгол улсад чухал хэрэгцээтэй байгаа аж үйлдвэрийн салбарын хүний нөөц, боловсон хүчнийг Япон улсад сургаж бэлтгэх, мөн Монгол улсын инженер, технологийн дээд боловсролын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилготой юм.

Зээлийн нөхцөл:

Хүү: Жилийн 0.20%

**ЛАВЛАХ УТАС:320777**

Эргэн төлөлтийн хугацаа: 20 жил

/Үүнээс эхний 6 жилд төлбөрөөс чөлөөлөгдөнө./

Худалдан авалтын нөхцөл: Чөлөөт

/2/ Японы дэвшилтэт бараа бүтээгдэхүүнийг танилцуулах төслийн бус буцалтгүй тусламж /эмнэлгийн болон асаргаа сувилгааны тоног төхөөрөмжүүд нийлүүлэх/ /Нийт дүн 750 сая иен/

Энэхүү буцалтгүй тусламжаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг ханган ядуурлыг бууруулахыг зорьж буй Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг худалдан авах хөрөнгийг олгох юм. Энэхүү хөрөнгөөр Монгол улсын Засгийн газар Японы орчин үеийн дэвшилтэт технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг худалдан авах ба ингэснээр Монгол улсын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад хувь нэмэр оруулахаас гадна Японы дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг Монголд нэвтрүүлэх, цаашид Японы компаниудыг Монголын зах зээлд үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг болно гэж найдаж байна.

/3/ Соёлын буцалтгүй тусламж “МҮОНРТ-ийн программийн хангамжийг сайжруулах төсөл” /Нийт дүн 71 сая 700 мянган иен/

Энэ нь МҮОНРТ-д Японы телевизийн чанартай боловсрол танин мэдэхүйн нэвтрүүлгүүд болон баримтат нэвтрүүлэг зэргийг худалдан авах хөрөнгийг олгох төсөл юм. Уг хамтын ажиллагааг хэрэгжүүлснээр эдийн засгаа эрчимтэй хөгжүүлэхийн нөгөөтэйгүүр уламжлалт соёлоо хадгалсаар байгаа Япон орны туршлагаас Монголын ард түмэнтэй хуваалцах боломж бүрдэх юм.

ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

--o0o--

**ЛАВЛАХ УТАС:320777**